

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР****Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

**Элсний нүүдэл**

/өгүүллэгийн хэсгээс/

...Их элсний захад би энэ дуртгалыг бодолдоо хэлхэж, зулайдаа цас чалмайлсан хөх уулсаа харж суулаа. “Амьд амьтан жаргаж байвал орчлон өөрөө жаргадаг” гэсэн алдуул үгийг би хаа нэгтээ сонссон байх юм. Ингэхэд энэ орчлонд илүү юм гэж байна уу, бодвол үгүй байх аа. Бид энэ газар дэлхийд хүн л байвал бусад нь хамаагүй мэт санах нь бас л ухаан цөлхийн шинж гэлтэй.

Их говийн наран дор тэмээ мал торолзож, хонин зэрэглээ мяралзан, энэ аниргүй мөчид ч элс нүүж л байгаа даа гэхээс сэтгэл гэгэлзэх ч шиг, цаанаа л уйтгартай.

Орхиод нүүсэн шувууд даль жигүүрээ цуцаан эргээд ирдэг бол газар шорооны минь алтан үртэс энэ манхан хонгор элс цаашаа л явна уу гэхээс наашаа цувахгүй. Тэнгэрийн дор амьдарч тэнгэрийнхээ дор төгсдөг нь хүний хорвоогийн жам гэвэл би биш элс үлдэнэ. Нүүсэн ч суусан ч үлдэнэ.

Угалзан хээтэй элс минь уул Алтайдаа л үлдэж хайрлаарай. Орчлонд илүү юм байдаггүй, тэгвэл манай Алтайд ч илүү юм үгүй. /С.Пүрэв/

1. Эхэд элсийг юу гэж адилтган нэрлэсэн бэ?
  - A. Алтан үртэс B. Угалзан хээ C. Хонин зэрэглээ D. Говийн наран E. Алтан шороо
2. Зохиогчийн санаа зовж буйг илтгэсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
  - A. Цөлжилт ихсэж мал амьтныг идэх ургамалгүй болгож байгаад...
  - B. Энэ дэлхийд хүн л байвал бусад нь хамаагүй мэт санаж байгаа тэнэгүүдэд...
  - C. Нуур ус, гол горхи ширгэж усгүй болоход хүрч байгаад...
  - D. Манхан хонгор элс урагшаа нүүгээд л байгаад...
  - E. Нуураа орхиод нүүсэн шувууд даль жигүүрээ цуцаан эргээд ирдэгбол нутгаасаа явсан хүн эргэж ирэхгүй байгаад...
3. Утгын хувьд эсрэгцсэн санаа бүхий өгүүлбэрийг олоорой.
  - A. Энэ газар дэлхийд хүн л байвал бусад нь хамаагүй мэт
  - B. Элс нүүж л байгаа гэхээс сэтгэл гэгэлзэх ч шиг, цаанаа л уйтгартай
  - C. Манхан хонгор элс цаашаа л явна уу гэхээс наашаа цувахгүй
  - D. Би энэ дуртгалыг бодолдоо хэлхэж, хөх уулсаа харж суулаа
  - E. Би биш элс үлдэнэ
4. “Зулайдаа цас чалмайлсан хөх уул” гэсэн дүрслэлийн илтгэж буй утгатай тохирохгүй хэсгийг олоорой.
  - A. Уулынхаа хормойд очиход мөнх цас нь толь мэт гялтганана /Б.М/
  - B. Тэргүүндээ цагийн мөнхөд цас мөсөн гялалзуулан дүнхийх уулслурсан одогч хугацааны гэрч болон үлдэнэ /Д.Ня./
  - C. Мөнгөн дээд орой нь  
Мөс цасанд хучигдмал  
Мөнх хөх тэнгэрийн  
Мөнгөн цагаан багана /Ц.Д/
  - D. Цагаан цасан малгайтай  
Ногоон модон хүрэмтэй  
Хөх усан хормойтой...
  - E. Холхи ууланд цагаан үүл ургаж  
Хорголзон эвхрэлдэн хөх огторгуйд оров.../В.И/



13. Цөм бус бүтэцтэй өгүүлбэрийг олоорой.  
 А. Би уулсаа харж сууна.  
 В. Тэмээ мал торолзоно.  
 С. Би хаа нэгтээ сонссон.  
 D. Зэрэглээ мяралзана.  
 E. Элс үлдэнэ.
14. Эхийн өгүүлбэрүүдээс тонгоргон хувиргасныг олоорой.  
 А. Шувууд даль жигүүрээ цуцаан эргээд ирдэг.  
 В. Тэнгэрийн дор амьдарч тэнгэрийнхээ дор төгсдөг нь хорвоогийн жам.  
 С. Сэтгэл гэгэлзээд ч байх шиг, цаанаа л нэг уйтгартай.  
 D. Их говийн наран дор хонин зэрэглээ мяралзаж, тэмээ мал торолзоно.  
 E. Энэ хорвоод илүү юм гэж байна уу, бодвол үгүй байх аа.
15. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын дээд зэрэгт хувиргасныг олоорой.  
 А. Би энэ дуртгалыг бодож, оройдоо цас хялмаалсан хөх уулсаа харж суулаа.  
 В. Их говийн наранд тэмээ мал торолзож, хонин зэрэглээ мяралзана.  
 С. “Амьд амьтан жаргаж байвал орчлон өөрөө жаргадаг” гэсэн үг хаа нэгтээгээс миний сонорыг мялаасан байх юм.  
 D. Угалзан хээтэй элс минь уул Алтайдаа л үлдээрэй.  
 E. Орхиод нүүсэн шувууд даль жигүүрээ цуцаан буцаад ирдэг.
16. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.  
 газар дэлхий, энэ орчлон, тэмээ мал,.....  
 А. газар шороо В. даль жигүүр С. хуруун чинээ D. таван хялгас E. орчлон өөрөө
17. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай үгийг олоорой.  
 А. дуртгал В. газар С. элс D. тэнгэр E. шороо
18. “...бодол хэлхэх”-холбоо үгийн “хэлхэх” гэсэн үгийн үндсэн утгад тохирохыг ньолоорой.  
 А. хүзүү сээрээрээ хэлхэлдэх В. хэлхээтэй яс С. арга ухаан сүвэгчлэх  
 D. хурууд хэлхэх E. ах дүүгийн хэлхээ
19. “Угалзан хээтэй элс минь уул Алтайдаа л үлдэж **хайрлаарай**” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг ямар утгаар орсныг олоорой.  
 А. хүсэх, наминчлах В. өгөхийн хүндэтгэл С. элбэрэн дотночлох  
 D. гамнах, арвилах E. бодох, тооцох
20. Төрөл биш утгатай үгийг олоорой.  
 А. гэдий- В. гэдгэнэ- С. гэдэлз- D. гэдгэр E. гэдрэг
21. Эхээс сонгосон үгсээс үгийн бүтцээр зөв задалсныг нь олоорой.  
 А. бод+0+л+д+оо В. мяр+лз+0+0+н С. зэрэг+л+0+ээ  
 D. тор+лз+0+ж E. амь+д+р+0+ч
22. “Их говийн наран дор тэмээ мал торолзож, хонин зэрэглээ мяралзана” гэсэн өгүүлбэрийн “наран дор” гэсэн үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?  
 А. шууд тусагдахуун В. өгүүлэгдэхүүн С. хамжсан тодотгол  
 D. байц E. шууд бус тусагдахуун
23. Зөв бүлэглэсэн /угсруулах холбоо/ хэсгийг сонгоорой.  
 А. хээтэй элс, хорвоогийн зам, говийн нар  
 В. тэмээ мал, алтан үртэс, хонин зэрэглээ  
 С. бодолд хэлхэх, газар шороо, сэтгэл гэгэлзэх  
 D. газар дэлхий, элсний нүүдэл, элсний зах  
 E. даль жигүүр, угалзан хээ, орчлон өөрөө
24. “Би зулайдаа цас чалмайлсан хөх уулсаа харж суулаа” гэсэн өгүүлбэр дэх өгөх оршихын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?

- A. Орших орны утга                      B. Багтах харьяалагдах утга                      C. Эзэмшлийн утга  
D. Зорил хүслийн утга                      E. Цаг хугацааны утга
25. “Хүйтэн цаг агаарт цасны ширхэг бүтээд үүл болж дэгдэхгүйгээр газар буух” гэсэн тайлбарт тохирохыг нь олоорой.  
A. хяруу унах B. хялмаа буух C. шүүдэр буух D. мөндөр шаагих E. манан буух
26. “Энэ аниргүй мөчид ч элс нүүж л байгаа даа гэхээс сэтгэл гэгэлзэх ч шиг, цаанаа л уйтгартай...” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.  
A. төсөөлөн барагцаалах                      B. жишин адилтгах                      C. батлан онцлох  
D. эс тоомсорлон адилтгах                      E. тааварлан барагцаалах
27. Аль өгүүлбэр нь эхэд хүний дотоод сэтгэлийн өөрчлөлт хувирлыг илэрхийлээгүй вэ?  
A. Сэтгэл гэгэлзэх ч шиг цаанаа л уйтгартай  
B. Цаашаа л явна уу гэхээс наашаа цувахгүй  
C. Алтайдаа л үлдэж хайрлаарай  
D. Нүүсэн шувууд даль жигүүрээ цуцаан ирдэг  
E. Манай Алтайд ч илүү юм үгүй
28. “Их говийн наран дор тэмээ мал торолзож, хонин зэрэглээ мяралзана” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ?  
A. -соор                      B. -нгоо                      C. -хлоор                      D. -нгуут                      E. -н
29. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.  
A. угалз, Алтай, бид, орчлон                      B. өөрөө, бид, энэ, өчнөөн  
C. нааш, би, цаашаа, хонгор                      D. наашаа, биш, өдий, угалз  
E. Алтай, би, наран, доор
30. Цэгийн оронд зөв бичгийн дүрмийн алдаагүй үгийг нөхөөрэй.  
Би биш элс .....  
A. нүүдэллэлээ                      B. нүүдэллээ C. нүүдэллээ D. нүүдлээ                      E. нүүдэллээ
31. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.  
A. Цай хийж өг! Наад цагаалга идээ шүүснээс авцгаа гэж шахаж шавдуулав.  
B. За тэгээд залуу насны хайр зарим нь бүтэж, зарим нь дурсагдах төдий өнгөрөхийг аль тэр гэх вэ.  
C. Хөлөг онгоц гэмтсэн хэдий ч, аз болоход, живсэнгүй.  
D. Эднийх сувай малаа ялгаад, энэ зунжин оторлож, тарга тэвээрэг авхуулжээ.  
E. Герман улсад нэг жилд хэлээ дээшлүүлэх хүмүүсийг бүртгэж байна.
32. Монголын нууц товчоо зохиолд: Чингис Жамухаас өдий иргэнэрэвгэж баясанхуримлах явцад Бүрибөх Бэлгүтэйн мөрийг ямар учраас цавчсан бэ?  
A. Хатагиновгийн нэг хүн морины уяанд ээрээс цулбуур хулгайлж баригдсаныг Бүрибөх өмөөрч  
B. Бүрибөх улсын бөх учраас Бэлгүтэйд дараа дийлэгдэж магадгүй учир найрыг далимдуулж хүчийг мохоох гэж  
C. Жүрхиновгийн хон Бэлгүтэйд өшөөтэй байсан учир  
D. Угаас сэлмээр цавчилдан тоглож байгаад тоглоом нь хатуудсан учир  
E. Хуримын үед Бэлгүтэй Бүрибөхөд хундага өгөөгүй учир
33. Монголын нууц товчоо зохиолд: Чингисийг шархтахад Зэлмэ дотоожтой явж дайсанд нэвтэрсний учир юу вэ?  
A. Замдаа ус туулна. Тэгээд цаана нь гарахад амрыг бодож явсан. Баригдвал хурдан үхүүлэх биз. Тиймийн тул нүцгэн явсан.  
B. Танд орох дуртай билээ. Манайхан мэдээд миний хувцсыг тайлахад би дотоожтой дутааж ирэв гэнэ. Тэд үнэмшээд хувцас өгч асарна. Тэгээд морь унаад буцаж ирнэ.  
C. Нүцгэн хүнийг барьж хорихгүй нь мэдээж гэж бодсон.  
D. Нүцгэн явахад биенд ямар нэгэн баримт болохоор зүйл байхгүй тул би сая хэсэг хүмүүст баригдаад нүцгэрсэн билээ хэмээнэ. Тэд үнэмшиж тавих биз.  
E. Дайсан этгээдийн харуул манааг нэвтрэхэд хувцасгүй байвал амар гэж үзсэн. Тэгээд



**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**

**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлцийг утгатай нь зөв харгалзуулаарай.


- |                           |                    |
|---------------------------|--------------------|
| a. Алаг бөөрийн холбоотой | 1. дандаа хамт     |
| b. Бөөрөөрөө нийлэх       | 2. маш дотно       |
| c. Нойтон хамуу шиг       | 3. хамаатан төрөл  |
| d. Зүү орох зайгүй        | 4. ижлээрээ нийлэх |
| e. Дотор уужрах           | 5. тайвшрах        |

2.2. Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- |                                   |                        |
|-----------------------------------|------------------------|
| a. Байгаад байвал барагдана       | 1. Бэлгэ дэмбэрлийн үг |
| Суугаад байвал сорогдоно          |                        |
| b. Хаан хаяагаа сөхөхөд           | 2. Зүйр цэцэн үг       |
| Заан адуугаа хураана              |                        |
| c. Зааны ширээр хөхүүрээ хийгээд  | 3. Ерөөл               |
| Зандан модоор бүлүүрээ хийгээд... | d.                     |
| Алим жимсний уурхайтай            | 4. Магтаал             |
| Алт мөнгөний баялагтай...         |                        |
| e. Хамба торгоор гэрээ дүүргэж    | 5. Онъсого             |
| Халзан хониор хотоо дүүргэж...    |                        |

2.3. Зурагт зааснаар нэртэй нь зөв харгалзуулаарай.

- a. богтос
- b. атгаал
- c. шаант
- d. сүүж
- e. дунд чөмөг



2.4. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3	4
a	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахад заавал эгшигтэй бичигдэх дүрмийг зөрчиж бичигдэх үг	тооц+ж	түүх+т	нөхөд+д	хот+д
b	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээхгүй үг	Ундрал+аас	Худаг+ийн	Бодол+оор	Буцал+аад
c	Зөөлний тэмдэг “и” болохгүй үг	барь+мал	шаагь+ж	захь+дал	уль+вал
d	Эгшигт гийгүүлэгч эгшиггүй бичигдэх үг	өгүүл+л	сум+л	хувин+ г	дугуйл+н
e	Эр үгэнд “ий”-г бичих үг	хоорондох	туурга	цардуул	зохиолч